



БАТЛАВ:Захирал

Д.Мягмар

Баянтээгийн нүүрсний ордыг ил уурхайн тээвэртэй ашиглалтын системээр тасралтгүй ажиллаж 2016 оны уулын ажил нь хөрс хуулалт, нүүрс олборлолт, нөхөн сэргээлт, ус таталт гэсэн дөрвөн хэсгээс бүрдэнэ. Уулын бэлтгэл ажлын хүрээнд шинээр траншей нээж хөрс хуулалтыг тээвэртэй ашиглалтын системээр явуулж. Энэ ажлыг уурхайн үндсэн техник болох ЭКГ-5А экскаватор, HYUNDAI-520-LC-9S гидро экскаватор-1ш, TEREX 3305E автосамосвал-2ш, Хово-60 автосамосвал-2ш, D65E бульдозер-1ш, авто ачигч SD-300-1ш, NORD BENZ автосамосвал-2ш, HUYNDAI-2900LC-7-1ш экскаватор зэрэг техникийн хослолоор хийж гүйцэтгэж байна.

Баянтээгийн нүүрсний уурхайн үйлдвэрлэлийн хүчин чадлын өсөлт нь аймгуудын эдийн засгийн тогтвортой хөгжилтэй холбоотой бөгөөд уурхайн хүчин чадлыг захиалагч буюу эхний хагас жилийн нүүрс олборлолтыг үндэслэн 2016 оны эхний хагас жилд 34.5 мян.тн нүүрс олборлох төлөвлөгөөний 46.0мян.тн нүүрсийг олборлож, 125.0 мян.м³ хөрс хуулах төлөвлөгөөний 196.0 мян.м³ хөрсийг хуулаад байна.

Хагас жилийн байдлаар: Маркшейдерийн багаж худалдан авах тендер зарлаж 43500.0мян.төг, МАЗ кран 14500.0мян.төгрөгөөр тус тус худалдан авч. 4 машины граж 16900.0мян.төг, цагаан гражны цонх 3659.5мян.төг, хойд зуухны баруун жигүүрийн магистраль шугамыг солих ажил 70%-тай явагдаж байна.

Захиргаа аж ахуй, үндсэн үйлдвэр, туслах үйлдвэрийн нийт ажилчдад 249855.8мян.төг цалин тавьж.

АМАН татварт-24285.9 мян.төг, агаарын бохирдолт-32311.8 мян.төг, ААНОАТ-12105.5 мян.төг, ХХОАТ-22249.3 мян.төг, нийгмийн даатгалд -56425.1мян.төгрөгийн татвар, төлбөр хураамж олгосон бөгөөд хэвлэл захиалгын зардал 1106.9мян.төг, томилолтын зардал 13421.5мян.төг, шуудан холбооны зардалд 1232.0мян.төг, ТУЗ-ын зардалд 3604.7мян.төг, сургалтын зардалд 2487.8мян.төгрөг тус тус зардал гарсан.

2016 оны хагас жилийн байдлаар 46.0 мян.тн нүүрс олборлон борлуулж 920.5 сая төгрөг, бусад орлогоос 36.4 сая.төгрөг, нийт 956.9 сая.төгрөгийн орлого олж, 1178.6 сая.төгрөгийн зардал гарч. 221.7 сая.төгрөгийн алдагдалтай ажилласан.

МЭДЭЭ ГАРГАСАН: Ерөнхий санхүүч

ЛЮ.АРИУНТУНГАЛАГ